

ЗҮҮНГАР-МАНЖИЙН ЭЛЧИН ХАРИЛЦААН ДАХЬ “БАГА ҮГ” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ ШИНЖ ЧАНАР

Л.ЭНХСАРУУЛ

Товч агуулга: Элчийн харилцаа бол хоёр улс бие биеэ хүлээн зовшоорч байгаагийн илрэл, тухайн улсын гадаад бодлогын нэгэн хэлбэр. Зүүнгарын хаад Манжид элч зарах, Манжаас Зүүнгарт элч илгээхдээ захидал явуулахын зэрэгцээ элчийн амаар “бага үг”-ийг хэлүүлдэг байжээ. Энэ нь захидалд олон хэрэг явдлыг дурдахаас зайлсхийх, тухайн асуудал дахь эсрэг талын байр суурийг тандах, захидлын үгнээс оор чухалд тооцогдох хэрэг явдлыг дурдах, цоон тохиолдолд захидлын үгийг давтаж хүчийг нэмэх зорилготой байв.

Түлхүүр үг: Зүүнгар, Манж, элч, “бага үг”

Ойрадын чуулганы зүүн гарын хунтайж Галдан 1671 онд ах Сэнгийн ширээг залгамжилж, зүүн гарын дотор гарсан зөрчил тэмцлийг шийдвэрлэн, улмаар зүүн, баруун гарын ноёдын дэмжлэгийг хүлээн хүчирхэгжээд, баруун гарын ахлагч Очирт сэцэн хантай эвдрэлцэн, цэргийн хүчээр буулган авч, олон зуун жилийн уламжлалтай Дөрвөн ойрадын чуулганы бүтцийг эвдэн, хаант засаглал бүхий Зүүнгар улсыг 1676 онд байгуулав. Зүүнгарын төрийг Цоросын угсааны Галдан бошогт (1676-1697), Цэвээнравдан (1697-1727), Галданцэрэн (1727-1745), Цэвээндоржнамжил (1745-1749), Ламдаржаа (1749-1752), Даваач (1752-1755) нар үе улиран барьсны эцэст, дотоодын самууны улмаас Манжид эзлэгдэв.

Тус өгүүлэлд, “Чин улсын магад хууль” 《请实录》, “Өдрийн тэмдэглэл” 《起居注》, “Найралт төв хааны манж бичгийн улаанаар цохсон айлтгалын бичгийн орчуулга” 《雍正朝满文朱批奏折全译》, “Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг”, “Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг”, “Дайчин улсын дотоод яамны монгол бичгийн гэрийн данс”, “Цэргийн тухайн газрын манж бичгийн Зүүнгарын элчийн дансны орчуулга” 《军机处满文准噶尔使者档译编》, “Чин улсын үсийн Шинжааны манж бичгийн архивын эмхэтгэл” 《清代新疆满文档案汇编》 зэрэг манж, хятад, монгол сурвалжуудыг ашиглан “бага үг”-ийн утга учир, шинж чанар, хэрэглээ, ач холбогдол зэргийг тодруулахыг оролдлоо.

Нэг. “Бага үг” хэмээх ойлголтын тухай

Зүүнгар-Манж харилцан элч илгээлцэхдээ захидал явуулахын зэрэгцээ олонх тохиолдолд элчийг захидал, амаар хэлэх үгийн хамт илгээдэг байжээ. “Бага үг” гэдэг нь Зүүнгар, Манжийн элч өөрийн улсын нэрийн өмнөөс ямар нэгэн асуудал, хэрэг явдал дахь уг улсын байр суурийг харилцагч талд амаар илэрхийлдэг захидлаас тусдаа биеэ даасан албан ёсны мэдэгдэл юм.

Зүүнгар-Манжийн харилцаатай холбогдох сурвалжуудаас, хоёр улсын харилцан элч илгээлцсэн тоог бүртгэвэл, Галдан Зүүнгар улсыг байгуулахаас өмнө 1672-1676 оны хооронд нийт найман удаа Манж руу элч илгээсэн байна. Зүүнгар улс байгуулагдсаны дараа 1677-1754 оны хооронд хоёр улс харилцан 160 гаруй удаа элч илгээлцэж, үүний дотроос Зүүнгараас Манж руу нийт 102 удаа, Манжаас Зүүнгар луу 58 удаа; Манж руу Галдан 35 удаа, Цэвээнравдан 31 удаа, Галданцэрэн 11 удаа, Цэвээндоржнамжал дөрвөн удаа, Ламдаржаа хоёр удаа, Даваач нэг удаа; Зүүнгар луу Энх-Амгалан 51 удаа, Найралт төв таван удаа, Тэнгэрийн тэтгэсэн хоёр удаа элч илгээжээ. Манжаас Галдан руу 26 удаа, Цэвээнравдан руу 28 удаа, Галданцэрэн рүү дөрвөн удаа; Зүүнгараас Энх-Амгалан руу 80 удаа, Найралт төв рүү долоон удаа, Тэнгэрийн тэтгэсэн рүү 15 удаа элч илгээсэн байна. Хамгийн анх 1691, 1727, 1746, 1751, 1754 онуудад Цэвээнравдан, Галданцэрэн, Цэвээндоржнамжал, Ламдаржаа, Даваач нар анхны элчээ Манж руу зарсан бол 1682, 1723, 1737 онуудад Энх-Амгалан, Найралт төв, Тэнгэрийн тэтгэсэн нар анхны элчээ Зүүнгар луу илгээжээ.

Зүүнгарт очсон 58 удаагийн элчийн бүлгүүд дотроос эдүгээ элчийн бүрэн тэмдэглэл нь мэдэгдэж байгаа долоон бүлэг байна. Үүнд, 1682 онд очсон дотоод сайд Хитад; 1689 онд очсон ГМТЗЯЯ-ны эрхин түшмэл Арнай; 1724, 1725 онуудад очсон бичгийн сайд Жунфубао, мэйрэний занги Жас, лам Чойн тойн, Шарав гэсэл; 1734 онд очсон дэд сайд Фунай; 1737 онд очсон Халхын туслагч тайж Эмгэн; 1738 онд очсон дэд сайд Акдун, шадар гуравдугаар зэрэг хиа сайд Ванжал, тэргүүн зэрэг тайж Эмгэн, ГМТЗЯЯ-ны шийтгэгч түшмэл сайд Юйбау, Халхын хошууг захирах занги сайд Намжил нарын элчийн бүлэг хамаарна.

“Бага үг” хэмээх нэр томъёо нь Галданцэрэн хааны үеэс захидал бичгүүдэд тогтворжин бичигдэж, Галдан бошогт, Цэвээнравдан хаадын үед *“аливаа үг урьд бичигт дутуу, бага үг элчийн аманд буй”*; *“бусад үг хоёр элчийн аманд буй”*; *“бага үгийг амаар айлтгамуй”*; *“учрыг амаар тодорхойлон айлтгамуй”*; *“аливаа учрыг цом Ёндон гэлэн амаар айлтгамуй”*; *“элчийн амаар гүйцээн айлтгамуй”*, *“нягтыг*

нь элчис амаар айлтгах” зэргээр захидал бичгүүдэд илэрнэ. Дээрх баримтнаас “бага үг”-ийн үүрэг, зориулалт харагдах бөгөөд захидалд дурдагдаагүй зүйлсийг гүйцээн мэдүүлэх, тухайн хэрэг явдлын өрнөл хийгээд өөрийн санаа бодол, байр суурийнхаа нарийн зүйлсийг илэрхийлэхдээ “бага үг”-ийг ашигладаг байсан нь Зүүнгарын хаадын захидал бичгүүдэд тодорхой тэмдэглэгджээ.

1684 онд Галдан бошогтын элч Гүен дурал “*amā medüölkü*”¹ үгтэй манжид ирсэн нь, сурвалжид илэрч буй зүүнгарын элч нарын авч очсон анхны “бага үг” байв. 1687 онд Галдан бошогт захидалдаа, “*baxan üge elj-yin aman-du bii*”² хэмээн бичсэн нь “бага үг”-ын анхны мэдээ. “Бага үг” нь манж сурвалж бичгүүдэд “*majige gisun*” хэмээн тэмдэглэгдсэн байдаг.

Манжийн хувьд “элч сайдуудын хамт нийлж, тодорхойлон хэлэлцээд тогтоо” хэмээх үг нь элчийг “бага үг”-тэй илгээснийг илэрхийлнэ. Тухайлбал, 1730-1733 оны үед Зүүнгар-Манжийн хооронд өрнөсөн Бархөл, Хэрсэн чулуу, Үүдэн цөл, Эрдэнэ зуугийн дайны дараа тасалдсан найрамдалт харилцааг сэргээхээр Найралт төв хаан дэд сайд Фунайг илгээж, хилийн зааг тогтоох хэлэлцээрийг дахин өрнүүлэхээр оролдов. Найралт төв Галданцэрэнд илгээсэн захидалдаа, урьд Лувсанданжиныг хүргэж ир хэмээн Тэлэйг буцаав, хоёр гурван жил болтол хариугүй учир хязгаарын газрыг сэргийлэн хоёр замд цэрэг суулгаж, үүнээс Тэлэй ирж учрыг асуусан үед уулзаж чадалгүй явдлын яамнаас уламжлан зарлиг буулгасанд, үүнээс Зүүнгар Бархөлөөр дайран орж, Эрдэнэ зууд ялагдсан өмнөх явдлуудыг дурдаад, “тиймийн учир эдүгээ тусгайлан дэд сайд Фунай, бичгийн дэд сайд Акдун, мэйрэний занги Лоли нарыг элч болгон зарж, чамтай нийлэн, миний санааг сэнхрүүлэн ухуулж харилцан цэрэглэхийг байж, олон амьтныг үүрд жаргаах хэргийг хэлэлцэтүгэй хэмээн илгээв. ... Чи миний зарлигийг даган цэрэг дайныг байж, бүгд үүрд жарган аж торсүгэй хэмээвээс миний энэ зарсан элч сайдуудын хамт нийлж, тодорхойлон хэлэлцээд тогтоо. Би хамаг хэргийг цөм элч сайдуудын амаар зарлиг буулгав” хэмээн бичсэн байна. Гол хэрэг хилийн зааг тогтоох асуудлын талаар захидал дээр тэмдэглэгдээгүй, өөрийн улсын байр суурыг Фунай амаар мэдэгдэхдээ, “хязгаар дахиныг үнэхээр үүрд сайн найртай болгохыг бодвоос хязгаар тогтоовоос зохимуй. Энэ хязгаар тогтооход Алтай хөвчийг хязгаар болгон тогтоовоос сая үүрд сайн найртай болмуй” хэмээв. Фунайг илгээх үеэр, Галданцэрэн болон Зүүнгарын ардын дурдан асууж болзошгүй хэрэг явдал, түүнд

¹ Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Дөрөвдүгээр боть. ӨМАХХ., 2005. Тал-4.

² Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Зургаадугаар боть. ӨМАХХ., 2005. Тал-80, 295.

өгөх хариу, мөн сүр хүчийг илтгэх, Зүүнгарын ардын сэтгэл зүйд нөлөө үзүүлэх үүрэг бүхий 11 зүйлийн аман зарлигийг Найралт төв хаан буулгажээ. Энэ нь, Зууд хан суулгах хэрэг; шашны хэрэг; Лувсандагжины хэрэг; цэрэглэсэн учрын хэрэг; Гүлэн, Гүмэн хийдийн учир; оргодлын хэрэг; халх өөлд нарын ураг барилдах хэрэг; урьд явдлын яамнаас илгээсэн бичгийн учир; Тэлэйгийн хоцроосон гурван хөтчийн учрыг асуувал хэрхэн хариулах зэрэг. Сүрийг үзүүлэн “манай дотоод, гадаад жанжин сайдууд цөм “цэрэг аваад даруй дайлан орсугай, эсвэл урьд Эрчист давшин, хот үйлдэж, цэрэг суулгаад, тариаланг элбэг түмээр хүргэж, алгуур давшилхийлэн орсугай” хэмээн огүүлжээ. Манай цэрэг хот үйлдэхэд огт хэцүү явдалгүй, нэг хоёр сарын хооронд даруй тогсгох” хэмээн өгүүлэх, сэтгэл зүйд нь нөлөөлж “манай их улсад нэг зүйлийн муу хор бүхий эм буй. Аливаа зэв сум, ирт юманд түрхэж хэрэглэвээс, арьс мах исгэн, даруй хор бадарч амь бармуй... таны Зүүнгар газарт урьд цайны навчгүй билээ. Арван хэдэн жилийн өмнө үзэх төлөгч ард “таны Зүүнгарын газар хэрэв цайны навч гарваас Зүүнгарын мөхөх цаг” хэмээн огүүдсэн билээ. Сонсвоос эдүгээ нэг зүйлийн цай буцалгах юм таны газар гарав хэмээмүй. Үнэн ташааг мэдэхгүй”³ хэмээн хэлэх зарлиг буулгасан байна. Фунайгийн тайлангаас үзвэл, Галданцэрэн захидлын бичиг дэх цэрэг хөдөлгөсөн учир шалтгаантай холбогдох асуудлыг хөндөж, Тэлэйгийн хоцроосон гурван хүний учир, Банчин-Эрдэнэ, Далай ламын мэндийг асуужээ.

Хоёр. “Бага үг”-ийн ангилал

Зүүнгар-Манжийн харилцааны бичгүүд дэх мэдээнд үндэслэн “бага үг”-ийг зорилго, чиглэл, биелэлт зэрэг хэд хэдэн хүчин зүйлс дээр тулгуурлан дараах байдлаар ангилж болно. Үүнд, “бага үг” ба захидлын үгийн уялдаа холбооноос хамааран, захидлын үгэнд дурдагдаагүй агуулгатай “бага үг”, захидлын үгтэй залгамж холбоотой “бага үг”, захидлын үгийн саагаг давтсан “бага үг”; элчээс хамааран элч өөрийн хааны нэрийн өмнөөс авч очсон “бага үг”, элч харилцагч улсын хааны нэрийн өмнөөс авч буцсан “бага үг” гэж ангилахаас гадна “бага үг”-ийн биелэлтээс нь шалтгаалан харилцан зөвшөөрөгдсөн “бага үг”, няцаагдсан “бага үг”, тохиролцоонд хүрсэн “бага үг” хэмээхийн зэрэгцээ “бага үг”-ийг хэрэглэх болсон зорилгоос нь хамааран тандах үүднээс хэрэглэсэн “бага үг”, байр сууриа илэрхийлэх зорилгоор хэрэглэсэн “бага үг” зэргээр ангилж болно.

³ 中国边疆民族地区历史与地理研究中心, 中国第一历史档案馆编译《军机处满文准噶尔使者档译》(上), 中央民族大学出版社, 2012. Баримт №8-15.

Тухайлбал, 1688 оны 6-р сард Галдан бошогт (1644-1697)-ын цэрэг Эрдэнэ зууд ирсэн тухай мэдээг лавлуулахаар манжийн эрхэлсэн сайд Арани тэмдэглэгч түшмэл Хайсандайг илгээсэн байна. Удалгүй 1688 оны 7-р сарын хар нохой өдөр Хайсандай Галдан бошогтын захидал, “бага үг”-тэй буцан иржээ. Захидалд, *“Живзундамба, Түшээт хан, дээд Далай ламын зарлигийг зөрчиж, Ширээтийг хүндэлсэнгүй тул би эндээс төр шашинд сайн нь мөн буйзаа хэмээн санааг хэлсэнд, харин ч бурууд болгож, цэрэглэн ирсэнийг Далай ламын адистид бид даруй ирж, суусан газрыг эвдлэв, тэр хоёр олноор зөвшөөхөөс гарсны тул аливаад очихгүй, очивч халгаахгүй буйзаа. Бас өчүүхэн сонссон бусад үг, Хайсандай заргачийн аманд бий”* гэж бичсэн байна. Хайсандайгийн амаар хэлсэн нь, Галданы үг *“Живзундамба эзнийг гуйн очвоос, халгаахгүй болгох ба эсвэл барьж бидэнд огох явдлыг уламжлан айлтгах ажсааму”*⁴ гэжээ. Энэ нь захидлын үгтэй залгамж холбоотой, харь элчийн авч буцсан, тандах зорилгоор хэрэглэсэн, няцаагдсан “бага үг”-ийн төрөлд хамаарагдах юм. Уг мэдээнээс, гол санаагаа захидлаар бус “бага үг”-ээр дамжуулан хэлсэн нь харагдана.

1696 оны Зуун модны дайны үеэр Хөхнуурын Бошгот жононгийн харьяат Лоорой эмч, Дүнрэв нар манжийн цэрэгт баригдаж, тавдугаар Далай лам таалал тогсоод удаж байгаа нууцыг задруулав. Удалгүй Энх-Амгалан (1654-1722) Дивад захидал илгээн, болсон хэрэг явдлыг үнэнээр хэлэхийг шаардан, шахалт үзүүлжээ. Дива захидалдаа, Цаньяанжамц нэгэнт арван таван нас хүрсэн учир ширээнд суулгахаар бэлтгэж байгаа тухайгаа бичсэн байна. Тэр үед Төвд хараахан Чин улсын шууд харьяат болоогүй байсан учир Энх-Амгалан (1662-1722) Төвд дэх нөлөөгөө бэхжүүлэх шаардлагын улмаас 1697 оны 3-р сард Цаньяанжамцыг VI Далай лам хэмээн өргөмжилж, тамга бичгийг хүргүүлжээ. Тухайн үед Цэвээнравдан (1663-1727) Диватай холбогдох асуудлаар өөрийн элчийг захидал, “бага үг”-ийн хамтаар Манжид илгээсэн байна. Цэвээнравдангийн элч рамжамба Пунцагданзан, Дорж нар 1697 оны 10-р сарын 26-ны өдөр Бээжин хотод хүрэлцэн ирж, Цэвээнравдангийн захидал ба “бага үг”-ийг уламжилжээ. Цэвээнравдан захидалдаа, *“Дива Далай ламын үг хэмээн Халхын долоон хошуу дөрвөн Ойрадыг хутгав, зонхавын шашиныг хиргүй болгож амьтныг жаргаахыг тольдоно уу”* цэрлэлгүй санаагаа гарган хэл хэмээсэн учир санаагаа гарган хэлэв, учрыг амаар тодорхойлон хэлнэ гээд элчийн амаар, *“Дива, богд Банчэнийг хорьж хүнтэй уулзуулахгүй улаан малгайн Дэрдун, Доржжэсав нар хоёр ламыг авчирч тахин, одоо [гарсан] Далай ламын хувилгааныг энэ хоёр ламын үгээр Далай лам болгосон*

⁴ Биеэр дайдж орно умарын газрыг товшигтөн тогтоосон бодлогын бичиг. Доровдүгээр дэвтэр.

төдий [богд Бан]чэний үг биш тул сэжиглэлтэй. Див зонхавын шашиныг [эвдэлж яв]муй. Үүнийг байлгаваас болохгүй”⁵ гэж Далай ламын гэм бурууг захидалдаа тодорхойлон бичээд, Далай ламыг зүгээр орхих нь буруу, түүний гэм нүгэлийг асууж шийтгэх хэрэгтэй хэмээн “бага үг”-ээр дамжуулан өөрийн байр сууриа илэрхийлсэн байна. Элч рамжамба Пунцагданзан, Дорж нарын авч очсон энэхүү “бага үг” нь захидлын үгтэй залгамж холбоотой, элч өөрийн хааны өмнөөс авч очсон, харилцан зөвшөөрөгдсөн төрөлд багтана.

Өөр нэгэн баримт дурдвал, 1730-1733 оны Зүүнгар-Манжийн дайн дууссаны дараа Найралт төв (1678-1735) Галданцэрэн (1693-1745)-д элч Фунай нарыг илгээн, найрамдах санал тавьсан байна. Үүний хариуд Чойнамка, Нохойни нар манжийн элчийг дагалцан захидал, “бага үг”-ийн хамт 1734 онд Бээжин хотод хүрэлцэн иржээ. Галданцэрэн захидалдаа, “эвдрэлгүй шарын шашиныг бадаруулан олон амьтныг жаргаах хэргийг их хаан тольдох уу? бага үгийг Чойнамка, Нохойни нар амаар айлтгамуй” хэмээн Найралт төв (1723-1735) хааны найрамдах саналыг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлээд, элчийн амаар, “Лувсанданжиныг омни нь барьсугай хэмээсэн билээ. Их хэрэг тогтоосны дараа Лувсанданжины хэрэг маанид хялбар. Жич хязгаар тогтоох хэргийг, Алтай угаас өөлдийн нутаг, Хангай халхын нутаг билээ. Зэрэг, Шар хулсын зэрэг газраас Бархөлд хүргэн хэлхээ болгох уу”⁶ хэмээн зүүнгарын янз, байдлыг үзэх зорилгоор сөхсөн Хөхнуурын Лувсанданжины хэрэг хийгээд гол асуудал “хилийн хэлэлцээр”-ийн талаарх байр сууриа “бага үг”-ээр илэрхийлжээ. Хожим Лувсанданжиныг Зүүнгарт хэвээр үлдээж, “Алтай ховчийг хязгаар болгон Хүсүн тохойгоос Хар барлагт хүргэн хооронд үлдэх газар болго; хэрэв Халхуудын нутгийг ойр хэмээн сэжиглэвээс бага аглаг болгож болно” хэмээн Зэрэг, Шар хулснаас Бархөлд хүргэн хэлхээ болгох саналыг нь хүлээн зөвшөөрөөгүй байна. Энэхүү “бага үг” нь захидлын үгэнд дурдагдаагүй агуулгатай, тохиролцоонд хүрсэн “бага үг”-ийн төрөлд хамаарна.

Галданцэрэн нас барсны дараа түүний хоёрдугаар хүү Цэвээндоржнамжил (1732-1749) хаан суурийг залгамжлав. Цэвээнравданы Төвд рүү хийсэн довтолгооны улмаас Төвд Манжийн нолоонд орж, Зүүнгарчууд Товдтэй харилцахын тулд Манжаас зөвшөөрөл авах ёстой болжээ. Цэвээндоржнамжил эцгийнхээ хойдын буяны тулд Баруун Занд хүн илгээж, манз чануулах хийгээд манз чануулан илгээх Зүүнгарын ардад замын морь, хүнсийг нөхөн олгохыг

⁵ Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Арван нэгдүгээр боть. ОМАХХ., 2005. Тал 434.

⁶ 中国边疆民族地区历史与地理研究中心, 中国第一历史档案馆编译《军机处满文准噶尔使者档译》(上), 中央民族大学出版社, 2012. Тал-230.

хүсэн 1745, 1746 онуудад элч илгээн харилцсны эцэст, эцгийнхээ хойдын буяны тул Баруун Занд манз чануулан, буян үйлдүүлсэн байна. Үүний дараа 1748 онд элч Анжийг илгээн захидалдаа, *“Зүүнгарт байгаа нас ахисан төвд лам нарыг нутагт нь буцаахад аль замаар Төвд рүү явуулах тухай”* асуун бичээд, *“Төвд лам нарыг Зүүнгарт илгээнэ үү; Су жоуд жил бүр худалдаа хийлгэх үү, худалдаа хийлгэх хүний тоог хоёр зуу болгох уу”* хэмээх “бага үг”-ээ дамжуулжээ. Үүний хариуд, *“Зүүнгарт удсан төвд лам нарыг нутагт нь буцаах тухай хэлэлцээрт байхгүй; Төвдөөс Зүүнгар луу лам илгээхгүй; Зүүнгараас хүн илгээж Бээжинд суулган ном заалгаж болно; Су жоуд нэг жил өнжөөд хоёр зуун хүн илгээн худалдаа хийлгэж болно”*⁷ хэмээн захидлын үгийг няцаагаад, “бага үг”-нд тохиролцоо санал болгосон байна.

Дээрх баримтуудаас Зүүнгарын хаад “бага үг”-ээр дамжуулан ямар асуудлуудыг Манжтай ярилцан шийдвэрлэж байсан, “бага үг”-ийн ангилал, төрлийн жишээ зэргийг харж болно. Тухайлбал, Галдан бошогт Живзундамба хутагтай холбогдох асуудлыг, Цэвээнравдан Диватай холбогдох асуудлыг, Галданцэрэн хилийн хэлэлцээртэй холбогдох асуудлыг, Цэвээндоржнамжил худалдаа, лам залах асуудлыг “бага үг”-ээр дамжуулан хэлэлцсэн байна. Сурвалжийн мэдээнүүдээс Зүүнгар, Манжийн хаад гол чухал асуудлаа “бага үг”-ээр дамжуулан хэлэлцдэг байсан нь ажиглагдана.

Гурав. “Бага үг” ба элчийн гүйцэтгэх үүрэг

Элч бол хоёр улсын харилцааг холбогч, уг улсын бие төлөөлөгч учир элчийн үг яриа, үйл хөдлөл нь тухайн ярилцан хэлэлцэж буй хэрэг явдлын шийдвэрлэлтэд дам байдлаар нөлөө үзүүлнэ. Тухайлбал, 1742 онд Галданцэрэн хаан захидалдаа, *“Чойнамка ирсэнд буулгасан их хааны зарлиг “Чойнамкагийн авч ирсэн айлтгах бичгийн үг хэгжүүн, амаар үг хичээнгүй эелдэг. Тиймийн учир чи Галданцэрэний тушаасан үг үгүй бол санааг дураар чимэн огуулэх хуульгүй учир би итгэв”* хэмээн зарлиг буулгахад би ихэл баярлав.”⁸ хэмээн бичиж байснаас элчийн чадвар хоёр улсын харилцаанд хэрхэн нөлөөлдөг нь харагдана. Ялангуяа элч “бага үг”-тэй очиж байгаа тохиолдолд элчийн санаачлага, нөхцөл байдлыг задлан шинжлэх, шийдвэр гаргах чадвар, үг, өгүүлбэрийн зөв сонголт, асуудлыг хөндөн гаргаж ирэх өнцөг зэрэг нь “бага үг”-ийн биелэлт, шийдвэрлэгдэх явцад дам ба шууд нөлөө үзүүлнэ.

⁷ 中国边疆民族地区历史与地理研究中心, 中国第一历史档案馆编译《军机处满文准噶尔使者档译》(中), 中央民族大学出版社, 2012. Тал 1733-1734.

⁸ 中国边疆民族地区历史与地理研究中心, 中国第一历史档案馆编译《军机处满文准噶尔使者档译》(中), 中央民族大学出版社, 2012. Тал-976.

Жишээ нь, 1696 онд Цэвээнравдан хааны элч Нансо (элчийн нэр биш хэргэм бололтой. Энэ нь шашны сүм хийдийн гадаад дотоод харилцааг эрхлэгч ламын хэргэм тушаалын нэр.) “бага үг”-ээ хэрхэн дурдан өгүүлсэнийг авч үзвэл; Тэрбээр эхлээд Энх-Амгалангийн 29-р (1690) онд заргач Даху, Сангэ нар Цэвээнравданы хажууд ирсэн үед, Галдан Цэвээнравданы дүүг алж, түүний эхнэр албатыг булаан авч, хөөсөн хийгээд хожим Цэвээнравдан Галдангийн нутгийг хураан авсан зэрэг өнгөрсөнд болсон Цэвээнравдан Манжийн найрамдлыг дурдан сануулаад, 1695 оны найман сард Галдангаас оргон ирсэн хоёр хүнээс Галдангийн зүдэрч яваа байдлыг сонссоноо хөдлөшгүй суурь болгон, гол хэрэг Хотонгийн асуудлаа ярьсан байна. Нансогийн хэлсэн нь, “Өнгөрсөн жил (1695) Галданы [...] торлийн хотон нийслэл хотод худалдаа хийхээр одсоныг оруулсангүй. [...] мүй хэмээн Галданаас оргож ирсэн оргодлын хэлэхийг сонсов. Энэ [...] худалдааны очсон хотон нар нийслэл хотод байваас надад илгээнэ үү. Үгүй бол дараа Галданы газраас хотон нийслэл хотод очих нь байваас Дээрхээс өршөөвөөс надад илгээнэ үү” хэмээн Манжийн зүгээс Галдангийн худалдааны хотон ирээгүй хэмээн мэлзэхээс сэргийлж, оргодлын үгийг баримт болгон ашигласан байна. Үүний хариуд, Манжийн сайдууд “худалдаа хийх хотон ирвээс Галданы хүнтэй хамт ирмүй. Хотон нарыг хэдий Цэвээнравданыг гуйж од хэмээн өгүүлэвч, Галданы хүн илгээхгүй бол хэрхэмүй” хэмээн асуусанд, Нансо “Галданы хүнийг салгаад, Галданы зүг илгээж, хотон нарыг Жиа ү гуанаар гаргаад Цэвээнравданыг гуйн од хэмээн илгээвээс болох уу”⁹ гэж харилцагч талын хариу, хандлагыг мэдсэний дараа нөхцөл байдалд тохирох арга замыг заан өгсөн нь харагдана. Уг баримтаас асуудлыг зөв талаас гарган ирсэн, цаг тухайд нь шийдвэр гаргасан хийгээд үг өгүүлбэрийг сонгосон байдал зэрэгт үндэслэн Нансогийн чадварыг үнэлж болно.

Зүүнгарын элчийн болгоомжгүй үг, түүнд үзүүлсэн Манжийн хариу үйлдлийн талаар нэгэн баримтыг эш татая. 1749 онд, Цэвээндоржнамжил хаан элч Нямыг захидал, “бага үг”-тэй илгээжээ. Захидал, “бага үг” нь Төвдөөс Зүүнгарт лам залуулах хүссэн агуулгатай байв. Манжийн тал Төвдөөс лам залуулахыг хүссэн Галданцэрэн, Цэвээндоржнамжил, Ламдаржаа хаадын хүсэлтэнд удаа дараа татгалзсан хариу өгсөн байдаг. Энэ нь Цэвээнравданы Төвд рүү хийсэн довтолгоотой холбогдож, Төвдийн ард Зүүнгарт дургүйцэх, Төвдөөс лам залах нэрээр Зүүнгарт тагнуул хийх, Төвд ардын санааг хувируулан үймүүлэхээс Манжийн тал эмээсэнд оршино. Элч, сайдуудын хэлэлцээрийн явцад Нямын

⁹ Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Арван нэгдүгээр боть. ӨМАХХ., 2005. Тал 430-434.

“Дайны хэрэг байв хэмээн худалдааг зогсоох хууль үгүй, шарын шашныг бадараах нь манай их хэрэг”¹⁰ гэсэн үгийг буруутгаж, найрамдсан энэ үед “дайн” гэх үг элчийн амнаас гарах нь зохисгүй, элч байтугай Цэвээндоржнамжил хялбараар хэлж болох үг биш, чиний хэлснээр дайн болтугай гэвэл манай тавьсан харуул, дарангуйлан суусан цэрэг эдүгээ боловч сууж байна, “энэ Нямын мунхаглан айлтгасан үг, Би хишиг хүртээн уучлан хэлтэрүүлж Цэвээндоржнамжилд буулгах зарлигт оруулан бичихгүй. Хэрэв оруулан бичвээс түүний тайж эрхгүй түүнийг буруушаамуй. Тэр хүлээн чадамуй юу. Түүнийг үүнээс хойш элч болж явахад амаар үг дэмий долгиран өгүүлвээс болохгүй” хэмээн Тэнгэрийн тэтгэсэн хаан зарлиг буулгасан байна. Ням “өчигдөр би зүгээр адилтган Наянтайд өгүүлэв. Бусад аймгийн дайны учир боловч харин худалдааг зогсоохгүй явуулах явдал ... найртайгаар нийлсэн сайнд жил бүр цөөхөнөөр хүнийг Занд илгээхийг гуйн өгүүлсэнээс бус их хаанд айлтгах үг бус. Үүнд Наянтай чи харин надад “таны тайж тушааж өгүүлсэн нь үү? чиний санаагаар тийнхүү өгүүлсэн нь үү?” хэмээн надад асуусанд би “зүгээр адилтган өгүүлэв” хэмээн хэлэв. Дайн хэмээгч машид муу хэрэг, би ямар зэрэг хүн, хооронд элч болж явахад би ямар аймшиггүй эвдэн өгүүлмүй. Их хаан хишиг хүртээн сургасан зарлигийг хичээнгүйлэн даган явсугай. Манай тайжид буулгах зарлигт оруулан бичихгүй нь үнэхээр туйлын хишиг” хэмээн хэлснээс Нямын болгоомжгүй үг хоёр улсын харилцаанд сэв үүсгэх дөхсөнийг харж болно. Тухайн үед Манжийн Зүүнгар луу цэрэглэх дайны бэлтгэл, Зүүнгарын дотоод нөхцөлд тохироо бүрдээгүй байсан учир Нямын “дайн” гэсэн үгээр шалтаг үүсгэсэнгүй.

Өөр нэгэн жишээ дурдвал, Цэвээндоржнамжилын дараа Зүүнгарын хаан ширээнд суусан Ламдаржаа (1727-1753) элч Эрхэн нарыг 1750 онд илгээсэн байна. Ламдаржаа захидалдаа, “Нийслэл хотын судар тарнид мэргэн ламыг дөрөв тав илгээж, Зүүнгарын лам нарыг дөрөв таван жил сургаж хойш илгээхийг тольдох уу” хэмээн бичээд, “бага үг”-ээр “манай газрын лам нар бие түүхий, нийслэл хотод ном сурган илгээж болохгүй явдлыг их хаан эрхгүй тольдмуй за. Өршөөвөөс намайг Зангаас дөрөв таван ламыг залаад манай газрын лам нарыг сурган дөрөв таван жил суулгаад хойш уг газарт илгээхийг тольдох уу” хэмээн захидалдаа нийслэл хотоос лам залуулахыг хүсэн бичиж, “бага үг”-ээр Зангаас лам залуулахыг хүссэн нь харилцан зөржээ. Үүнд Манжийн тал “Зангаас лам залах хэргийг явуулахгүй гэх байтугай нийслэл хотоос мөн лам явуулахгүй” хэмээн дургүйцсэнд, Эрхэн “манай тайж намайг их хааны хишгийг гуйн айлтга хэмээн надад тушаасан

¹⁰ 中国边疆民族地区历史与地理研究中心，中国第一历史档案馆编译《军机处满文准噶尔使者档译》（下），中央民族大学出版社，2012. Тал-1992.

ёсоор айлтгажээ. Хэрхэж болговоос зохих хэргийг их хаан тольдоход буй” хэмээн нөхцөл байдлыг зөөлрүүлсэн байна.

Үүний дараа Эрхэн аяыг үзэн, Ламдаржаа хааны үүрэг болгосон бас нэгэн “бага үг”-ийг хэлсэн байна. Энэ нь “манай тайж олвоос Занд хүн зарж, хоёр богд дөрвөн их сүмд бэлэг барин бичиг оргон барих хэргийг их хаан хишиг хүртээн явуулваас болох уу”¹¹ хэмээсэнд, гал дээр тос нэмэхтэй адил нөхцөл байдал үүсэв. Сурвалж бичгийн мэдээнүүдээс харвал, хоёр талын элч харилцан ирж явахдаа, өөрийн хаадын санаа бодол, байр суурийг илэрхийлэн, нөгөө талын байр байдлыг тандаж байх үед зөрчил үүсэх, яриа ширүүсэх үед, элч нарын бултах нэгэн арга зам нь “манай тайж, манай хааны үг, би элч төдийхөн” хэмээх үгээр хурцадмал нөхцөл байдлаас гарч байсан нь ажиглагдана. Дээрх баримтнуудаас “бага үг” нь элчийн амаар дамжин илэрхийлэгддэг, элчийн үг, чадвар нь “бага үг”-ийн биелэлт цаашлаад тухайн хоёр улсын харилцаанд хэр нөлөө үзүүлдэгийг харж болно.

Дүгнэлт

Зүүнгар улс оршин тогтнох хугацаандаа Чин улстай цэрэг хөдөлгөн дайтах, худалдаа арилжаа хийх, элч илгээн ярилцан хэлэлцэх, найрамдах зэрэг тал бүрээр харилцаж байв. Хоёр улс 1677-1754 оны хооронд харилцан 160 гаруй удаа элч илгээлцэж, олонх тохилдолд элчийг захидал, “бага үг”-тэй хамт явуулдаг байжээ. Энэ нь захидалд олон хэрэг явдлыг дурдахаас зайлсхийх, тухайн асуудал дахь эсрэг талын байр суурийг тандах, захидлын үгнээс өөр чухалд тооцогдох хэрэг явдлыг дурдах, цөөн тохиолдолд захидлын үгийг давтаж хүчийг нэмэх зорилготой. Сурвалжийн мэдээнээс, хоёр тал элчийг захидал, “бага үг”-тэй илгээж байгаа тохиолдолд, захидлаар бус “бага үг”-ээр дамжуулан чухал, гол асуудлаа ярилцдаг, хэлүүлдэг байсан нь ажиглагдана.

“Бага үг”-ийг зорилго, чиглэл, биелэлт зэрэг хэд хэдэн хүчин зүйлсээс хамааран дараах байдлаар ангилж болно. Үүнд, “бага үг” ба захидлын үгийн уялдаа холбооноос хамааран захидлын үгэнд дурдагдаагүй агуулгатай “бага үг”, захидлын үгтэй залгамж холбоотой “бага үг”, захидлын үгийн санааг давтсан “бага үг”; элчээс хамааран, элч өөрийн хааны нэрийн өмнөөс авч очсон “бага үг”, элч харилцагч улсын хааны нэрийн өмнөөс авч буцсан “бага үг” гэж ангилахаас гадна “бага үг”-ийн биелэлтээс нь шалтгаалан харилцан зөвшөөрөгдсөн “бага үг”, няцаагдсан “бага үг”, тохиролцоонд хүрсэн “бага үг” хэмээхийн зэрэгцээ “бага

¹¹ 中国边疆民族地区历史与地理研究中心, 中国第一历史档案馆编译《军机处满文准噶尔使者档译》(下), 中央民族大学出版社, 2012. Тал 2285-2290.

үг”-ийг хэрэглэх болсон зорилгоос нь хамааран тандах үүднээс хэрэглэсэн “бага үг”, байр сууриа илэрхийлэх үүднээс хэрэглэсэн “бага үг” зэргээр ангилна.

Элч бол хоёр улсын харилцааг холбогч, тухайн улсын бие төлөөлөгч учир элчийн гүйцэтгэх үүрэг асар их. Ялангуяа элч “бага үг”-тэй очиж байгаа тохиолдолд, элчийн үг яриа, үйл хөдлөл нь тухайн ярилцан хэлэлцэж буй асуудалд дан ба шууд байдлаар нөлөө үзүүлж байгаагаас уг элчийн авьяас чадварыг харж болно. Сурвалжийн мэдээнээс харвал, нөхцөл байдал хурцадах, тухайн асуудлын шийдвэрлэлт нь хааны захиас, саналаас өөр болох үед элч нар *“манай тайж, манай хааны үг, би элч болж явах бага хүн төдий”* зэрэг үгээр таагүй нөхцөл байдлаас цэвэрхэн мултардаг байжээ.

Abstract : The Zhunghar rulers (Caldan Boshogtu, Tsewang Arabtan, Galden Tsering, Tsewang Dorj Namjil, Lamadarja, Dawach) from 1672 to 1754 year has sent to around one hundred times envoy to the Qing. The Zhunghar empire wrote letters to the Qing emperors and used oral messages conveyed “small words”. Of these has sent to around twenty five times “small words”. By utilizing records related to Zhunghar’s envoy in manchu script archives, this article the author to analyze the nature of these “small words”.

Ном зүй

1. Биеэр дайлж өрнө умрын газрыг товшитгөн тогтоосон бодлогын бичиг. Дөрөвдүгээр дэвтэр.
2. Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Дөрөвдүгээр боть. ӨМАХХ., 2005.
3. Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Зургаадугаар боть. ӨМАХХ., 2005.
4. Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Арван нэгдүгээр боть. ӨМАХХ., 2005.
5. 中国边疆民族地区历史与地理研究中心, 中国第一历史档案馆编译《军机处满文准噶尔使者档译》(上), 中央民族大学出版社, 2012.
6. 中国边疆民族地区历史与地理研究中心, 中国第一历史档案馆编译《军机处满文准噶尔使者档译》(中), 中央民族大学出版社, 2012.
7. 中国边疆民族地区历史与地理研究中心, 中国第一历史档案馆编译《军机处满文准噶尔使者档译》(下), 中央民族大学出版社, 2012.